

ҮЙЛ ЯВДАЛ ТЭМДЭГЛЭЛТ ОЙ

Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн хурлын 9 дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы тухай

Н.ТӨМӨР

БХАТХ-ын ес дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1998 оны 3-р сарын 5-наас 19-ний өдрүүдэд Бээжинд болов. БНХАУ-ын муж, өөртөө засах орон, хот болон Ардын чөлөөлөх армиас сонгогдсон 2979 төлөөлөгчид их хуралд оролцсоноос ӨМӨЗО-ноос 57 төлөөлөгчид оролцжээ.

БХАТХ-ын ес дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганд засгийн газрын ажлын тухай тайлан итгэлийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэн, Улс ардын аж ахуй, нийгмийг хөгжүүлэх 1997 оны төлөвлөгөөний биелэлтийн тухай илтгэлийг Улсын төлөвлөгөөний комиссын дарга Чэнь Цзинхуа, 1997 оны улсын төсвийн гүйцэтгэл болон 1998 оны төсвийн төслийн тухай илтгэлийг Сангийн Яамны сайд Лю Чжунли, БХАТХ-ын Байнгын хорооны ажлын тухай илтгэлийг найм дахь удаагийн сонгуулийн БХАТХ-ын Байнгын хорооны дэд дарга Тянь Цзюнь, Ардын Дээд шүүхийн ажлын тухай илтгэлийг Ардын Дээд шүүхийн дарга Жэнь Цзянсин, Ардын Дээд прокурорын газрын ажлын тухай итгэлийг Ардын Дээд прокурорын ерөнхий прокурор Чжин Сыцин нар тус тус тавив.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэн засгийн газрын ажлын тухай илтгэлдээ БНХАУ-ын Эдийн засгийн хөгжлийн асуудал, гадаад бодлогын үндсэн чиглэлийн талаар тодорхой яриу. Тэрээр эдийн засагт олсон амжилтын талаар хэлэхдээ, 1997 оны байдлаар БНХАУ-ын үйлдвэрлэлийн нийт хэмжээ 74772 дүнчүүр юаньд хүрсэн бөгөөд энэхүү үйлдвэрлэлийн нийт хэмжээ өнгөрсөн таван жилд жилээс жилд дунджаар 11%-иар өсөн нэмэгдэж, Наймдугаар Таван жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлэв гэж тэмдэглээд 1997 онд 492,5 тонн үр тариа, 100 сая гаруй тонн ган, 250 сая киловатт цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэн, 1134 км-ын төмөр замыг шинээр тавив гэжээ. Ли Пэн илтгэлдээ өнгөрсөн таван жилд тус орны экспорт, импортын нийт хэмжээ 3251 дүнчүүр ам.долларт хүрч, улсын санхүү эдийн засгийн ерөнхий байдал сайн байгааг тэмдэглээд гадаад валютын нөөц 1399 дүнчүүр ам.доллар хүрэв гэжээ.

Ли Пэн тус орны аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өсөлт түргэн хурдацтай байгааг хэлээд улс орныхоо эдийн засгийг цаашид улам эрчимтэй хөгжүүлэхийн тулд юуны өмнө өөрчлөлт шинэчлэлт хийх арга замаар ашиггүй муу ажиллаж буй улсын том, дунд үйлдвэрүүдийг ашигтай

ажиллуулах арга хэмжээ зайлшгүй авах шаардлагатай хэмээн илтгэлдээ тэмдэглэжээ. Тэрээр илтгэлийнхээ гадаад бодлогын хэсэгт ОХУ, АНУ, Япон, Европын орнууд, дэлхийн бусад бүс нутгийн улс орнуудтай БНХАУ харилцаж байгаа асуудлыг хөндөж ярих. БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд БНХАУ, АНУ-ын хоорондын харилцааны талаар ярихдаа "БНХАУ-ын дарга Цзян Цземин өнгөрсөн жил АНУ-д төрийн айлчлалыг амжилттай хийснээр хятад-америкийн харилцаа хөгжлийн шинэ үе шатанд оров" гэж тэмдэглээд БНХАУ, ОХУ-ын хоорондын харилцааны талаар ярихдаа "БНХАУ, ОХУ-ын хоорондын харилцаа цаашид хөгжиж байна. Хоёр улсын хооронд "Олон туйлт ертөнцийн тухай болон олон улсын шинэ дэг журам тогтоох тухай" хамтарсан мэдэгдэл гаргасан бөгөөд мөн холбогдол бүхий хэлэлцээрийн дагуу хоёр улсын зүүн хэсгийн улсын хилийн шугам тэмдэг тавих асуудлыг шийдвэрлэсэн. Хоёр орны эдийн засаг худалдаа, шинжлэх ухаан техник зэрэг салбар дахь хамтын ажиллагаа, харилцаа солилцоог цаашид өргөтгөн, олон улсын асуудлаар хэлэлцэн ярилцах болон хамтран ажиллах явдлыг эрчимжүүлэх хэрэгтэй" гэжээ.

Ес дэх удаагийн сонгуулийн БХАТХ-ын анхдугаар чуулганаар БНХАУ-ын даргаар Цзян Цземин, орлогч даргаар Ху Цзиньтао нарыг, БХАТХ-ын Байнгын хорооны даргаар Ли Пэн, орлогч даргаар Тянь Цзюнь, Се Фэй, Цзян Чун-юн, Цзоу Цзяхуа, Пабала-Гэрэлландзе (төвд үндэстэн), Ван Гуан ин, Чэн Сыюан, Бөхөө (монгол үндэстэн), Темура-Давамади (уйгур үндэстэн), У Цзепин, Пэн Пэй-юн, Хэ Лули, Чжоу Гуанчжао, Чэн Кэцзе (Чжуан үндэстэн), Цао Чжи, Ди Шисун, Чэн Сывэй, Сюй Цзялу, Цзян Чжэнхуа нарыг, нарийн бичгийн даргаар Хэ Чунлинийг, гишүүнээр 133 хүнийг, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн даргаар Цзян Цземинийг, БНХАУ-ын Ардын Дээд Шүүхийн даргаар Сяо Яныг, БНХАУ-ын Ардын Дээд Прокурорын Газрын ерөнхий прокуророор Хан Чжубийнийг тус тус сонгожээ. Мөн чуулганаас 41 яам хорог 29 болгон цоомтгох тухай шийдвэр гаргажээ. Энэ шийдвэр ёсоор 22 яам хороог хэвээрээ үлдээж, 4 яам хороог шинээр байгуулан, 3 яам хорооны нэрийг сольж өөрчлөв. Үүнд: БНХАУ ын Батлан хамгаалах, шинжлэх ухаан техникийн аж үйлдвэрийн хороо, БНХАУ-ын мэдээлэл, шинжлэх ухаан техникийн аж үйлдвэрийн хороо, БНХАУ-ын Мэдээлэл, үйлдвэрлэлийн яам, БНХАУ-ын хөдөлмөр ба нийгмийн хамгааллын яам, БНХАУ-ын Улсын газар, нөөц баялагийн яам зэрэг 4 яам хороог шинээр байгуулж, БНХАУ-ын Төлөвлөгөөний Комиссыг БНХАУ-ын Улсын хөгжил, төлөвлөгөөний комисси, БНХАУ-ын Шинжлэх ухаан техникийн хороог БНХАУ-ын Шинжлэх ухаан техникийн яам, БНХАУ-ын Улсын боловсролын хороог БНХАУ-ын Боловсролын яам болгон нэрийг сольж өөрчлөв.

БХАТХ-ын ес дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы шийдвэрийг үндэслэн БНХАУ-ын даргын зарлигаар Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдаар Чжу Жунцзи-г, ерөнхий сайдын орлогчоор Ли. Ланцин, Цян Цичэн, У Бинго,

Вэн Цзябао нарыг, гишүүнээр Чи Хаотянь, Ло Гань, УИ, Исмайил Аймат, Ван Чжун-Юй нарыг, нарийн бичгийн даргаар Ван Чжун-юйг, Гадаад явдлын яамны сайдаар Тан Цзясюнийг, Батлан хамгаалах яамны сайдаар Чи Хаотянийг, Улсын хөгжил, төлөвлөгөөний комиссын даргаар Зэн Пэй-янийг зэрэг 29 яамны сайд, хорооны дарга нарыг томилов.

БХАТХ-ын ес дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1998 оны 3-р сарын 19-нд Бээжинд дуусч, төгсгөлийн хуралдаан дээр БНХАУ-ын дарга Цзян Цземин, БХАТХ-ын Байнгын хорооны дарга Ли Пэн нар үг хэлэв. Цзян Цземин хэлсэн үгэндээ, "Бидний тэмцлийн зорилт нь улс тунхагласны 100 жилийн ойн үед шинэчлэлийг үндсэндээ хэрэгжүүлэн, эх орноо баян хүчирхэг, ардчилсан соёлт социалист орон болгон бүтээн байгуулсан байх болно" гэжээ. Энэ нь ирэх 21-р зуунд БНХАУ эдийн засгийн өөрчлөн байгуулалт, нээлттэй бодлогоо цаашид явуулж социализмын замаар замнахыг харуулав.